



107 Page



108 Page



109 Page



110 Page

Moses3

-Moses3-

Тайлбарлагч Мосе Израильчуудыг дагуулан, Канаан уруу очих уртын урт аялалд гарчээ. Бурхан, тэднийг улаан тэнгисийн цаадах цөлийн зам уруу удирдав. Бурхан тэдний замыг өдөр нь үүлэн багана, шөнө нь галан баганаар удирдаж байлаа.

Хүмүүс “Биднийг удирдан чиглүүлдэг Бурхан минь, танд маш их баярлалаа”

Тайлбарлагч Тэд явсаар улаан тэнгист тулж ирэв. Тэд майхнаа барьцгаан хүмүүсийг амраалаа. Ядарсан ард түмэн уртын урт аялалаа түр зогсоон амарчээ.

Тайлбарлагч Харин Фараон хаан Израильчуудыг явуулсандаа харамсаж байв.

Фараон “Би, тэнэг зүйл хийжээ. Израильчууд байхгүй бол хэн миний ажлыг хийх билээ? Тэднийг буцаан авчиръя байз. Хурдан морьд цэргүүдийг бэлдэж, хойноос нь элдэн хөөе. Тэднийг боолын амьдралд нь буцаан оруулая.”

Тайлбарлагч Төд удалгүй морьт цэргүүд цөлийн зам уруу чиглэн давхицгаав.

Тайлбарлагч Далайн эрэг дагуу амарч байсан Израильчууд холоос ирж байгаа Египетийн цэргүүдийг хараад ихэд айцгаалаа.

Эмэгтэй “Биднийг цөлд алахаар ирж байгаа байх нь ээ?”

Эрэгтэй “Ингэж үхэх гэж. Египетэд боол байсан маань дээр байж дээ!

Тайлбарлагч Тэд Египетийн цэргүүдийг харан айцгааж, Мосед гомдоллож эхлэв.

Мосе “Бүү айгтун. Бурхан биднийг аврах болно”

Тайлбарлагч Энэ үед Египетийн цэргүүд улам дөхөн ирж байлаа.

Тайлбарлагч Бурхан Мосед ингэж хэлэв.

Бурхан “Мосе, чи ард түмнийг дагуулан улаан тэнгисийг гатал! Чи өөрийнхөө таягыг өргөн, далай дээгүүр сунга. Тэгвэл далай хоёр хуваагдаж, Израильчуудын хөлөнд ус хүрэхгүйгээр гатлах болно.”

Тайлбарлагч Мосе, Бурханы хэлсний дагуу далай руу таягаа чиглүүлэн сунгав. Тэгмэгц хаанаас ч юм хүчтэй салхилан салхилсаар далайн усыг хоёр хэсэгт хувааж, хуурай газрыг ил гаргалаа. Ус хоёр хэсэгт хана мэт овоорон, зам гаргажээ.

Хүмүүс “Хүүе, далай хоёр хэсэгт хуваагдчихаж!

Тайлбарлагч Хүмүүс баярлалдан хөөрч, болгоомжтойгоор далайн дундах хуурай газраар явцгаав. Ийнхүү Израильчууд бүгд эсэн мэнд гаталж чаджээ.



111 Page

-
- Тайлбарлагч** Египетийн цэргүүд ч ойртон ирж тэдний араас далайн дундах хуурай зам уруу орцгоов.
- Бурхан** “Гараа далай уруу чиглүүлэн өргө”
- Тайлбарлагч** Мосе, Бурханы хэлсний дагуу гараа далай уруу чиглүүлэн өргөхөд далайн ус хэвийн байдалдаа оров. Өнөөх Египетийн цэргүүд уснаас буцан гарч амжилгүй живцгээлээ.
- Хүмүүс** “Хөөх! Бурхан үнэхээр агуу юмаа!”
- Тайлбарлагч** Израильчууд бүгд Бурханд талархал өргөв. Ард түмэн Бурхан болон Мосед итгэцгээжээ. Ингэж Мосе Израильчуудыг Бурханы амлалтын газар болох Канаан нутаг уруу удирдахаар дуудагдсан хүн болохоо харуулсан юм.